



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 113

Дадал сум

**Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох
ажиллуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Иргэний хэрэг шүүхэд шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 35.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Сум хөгжүүлэх сан", "Жижиг дунд бизнесийг дэмжих дэд сан", "Хоршоо хөгжүүлэх сан"-гаас зээл авч хугацаа хэтрүүлсэн иргэдийн зээлийн асуудлаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Хөдөө аж ахуйн тасгийн Хүнс, Жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Т.Оюун-Эрдэнэ)-ийг нэг жилийн хугацаагаар томилох ажиллуулсугай.

2.Итгэмжлэгдсэн төлөөлөгч (Т.Оюун-Эрдэнэ)-д Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-25.1.7-д заасан эрхийг эдлэх бүрэн эрхийг олгосугай.

3.Холбогдох бичиг баримтыг бүрдүүлж хуулинд заасан эрхээ хэрэгжүүлж ажиллахыг мэргэжилтэн (Т.Оюун-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000030